

74.268.1

Д 15

128001

Х. ДАЛХАЖАВ

ДУНД СУРГУУЛЬД МОНГОЛ ХЭЛ  
БИЧИГ ЗААХ АРГА

УЛСЫН ХЭВЛЭЛИЙН ГАЗАР  
УЛААНБААТАР—1959 он



74.268.1

Д.15

УЛСЫН БАГШИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ХЭЛ БИЧГИЙН ТИНХИМ

Х. ДАЛХАЖАВ

ДУНД СУРГУУЛЬД МОНГОЛ ХЭЛ  
БИЧИГ ЗААХ АРГА

Редактор Ж Назмид

*[Handwritten Mongolian text, likely a preface or introduction, written in blue ink. The text is dense and covers a large portion of the page.]*

Б.Н.М.А. Улсын Гэгээрлийн Яамны хэвлэл 128001

УЛААНБААТАР—1959 он

**МАУ ЦБС**  
г. Улан-Удэ

Техн Ред Б. Дашлэгцэг  
Хянагч Б. Самдан

Б—885. Хэвлэлтэнд 1959 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр  
8000 ширхэг хэвлэв. Цаасны хэмжээ 60×92 1/16 Хэв. хуудас 13  
Зах № 34

---

Сүхбаатарын нэрэмжит Хэвлэх үйлдвэр.  
Улаанбаатар Чойбалсангийн гудамж, 2.

СЭНГЭЛЭГ  
СЭНГЭЛЭГ

## ӨМНӨХ ҮГ

Манай улс гэртээ эрт мянга гаран жилийн өмчөөс бичиг үсэгтэй болж, тэр бичиг үсгээ хойч үедээ сургасаар иржээ. Ингэж сургаж байсан арга туршлагыг бичиж тэмдэглэсэн ном судрын зүйл маш ховор байна.

Ийм учраас хувьсгалаас өмнө бичиг үсгээ сургаж байсан арга туршлагыг судлах аргагүй шахам байна.

Гагцхүү манай дээр үеэс эхлэн хэрэглэж байсан цагаан толгойг үзэхэд цагаан толгойн үсгийг үзэж дуусмагц үгийн эцэст дэвсгэрлэн ордог үсгүүдийг  $\text{тсг} \cdot \text{тсг} \cdot \text{өсг} \cdot \text{тсг} \cdot$   
 $\text{н} \cdot \text{тн} \cdot \text{өн} \cdot \text{тн} \cdot \text{тсг} \cdot \text{тсг} \cdot \text{өсг} \cdot \text{тсг} \cdot$   
гэх зэргээр үзүүлсэн нь гаднаас нь харахад үг биш утга, учиргүй үе боловч уг чанартаа үсгүүдээ таньж сая уншиж эхэлж байгаа хүнд 3,4 үсгүүдээр 1,2 үеийг бүтээж, үсэглэн эвлүүлж, уншихад хялбархан, уншлагын эхэн шат болсноороо ашигтай зүйл байжээ.

Энэ бол заах аргад маш холбогдолтой зүйлийн нэг юмаа. Түүнчлэн сая сурч байгаа хүнийг цэвэр бичигдсэн үе үсгээс эхлэн данс бичиг ихэд хуулуулдаг байжээ. Энэ бол бичиж сурах, үе үсгүүдээ нүдлэн тогтоох явдалд тэр үедээ нилээд ашигтай зүйл байжээ.

Манай сургуулийн сурагчдын сурлагын сүүдэртэй талын нэгд хэл бичиг ордог. Энэ чухам юунаас болж байна? гэдгийг нарийвчлан хянаж үзэх цаг боллоо. Манай хуучин бичгийн үгийн үеүүдийг бичих дүрэм нарийн биш, анхны дүрэм хэмжээ нь одоо хүртэл уламжлагдаагүй зэргээс үсгийн дүрэм нь нилээд хүнд байсан. Харин одоогийн шинэ бичгийн үе, үгийг бичих дүрэм нилээд тодорхой. Гэтэл үсгийн дүрмийг сайтар ойлгуулж чадахгүй байгаа явдал бол гагцхүү заах арга дээр л байгаагаас зайлахгүй болж байна.

Заримдаа бага сургууль төгсгөгчдийн дотор уншихдаа муухан, бичихдээ бүр ч муу хүүхэд байдаг. Бас дунд сургууль төгсгөгчдийн дотор ч зөв бичих дүрмийн чухал зүйлийг мэдэхгүй сурагчид байдаг нь дээд сургуулиудын элсэлт зэргээс нотлогдож байна. Ийм болохоор бид багш нар тус тусынхаа зааж байгаа арга туршлагаа сайтар хянаж, чухам яаж заавал баттай сайн ойлгогдгийг туршин судалж, манай ирээдүйг шийдвэрлэгч, хойт үеэ эрдэм чадалтай хүн